

# Millersville University



## Миллерсвил Их сургуулийн тухай

Миллерсвил Их сургууль оюутнууд маань чадавхаа бүрэн дүүрэн ашиглах боломжтой дэлхийн түвшний боловсрол олгодог. 1855 онд байгуулагдсан өнөөгийн Миллерсвил Их сургууль бол Америкийн Нэгдсэн Улсад бүс нутагтаа хамгийн нэр хүндтэй улсын сургуулиудын нэг юм. Миллерсвил Их сургуульд ойролцоогоор 8,000 оюутан суралцаж дэлхийн өнцөг булан бүрийн 30 гаруй улс орныг төлөөлдөг. Миллерсвил Их сургуулийн оюутнууд 100 гаруй бакалавр, магистрын хөтөлбөрөөс сонгож суралцдаг. Миллерсвил Их сургуулийн оюутнуудад том их сургуулийн нөөц боломж, тусалж дэмждэг хамт олон гэсэн хоёр том давуу тал бий.

2017-2018 оны багцаалсан зардал  
хичээлийн нэг жилд ам.доллаароор

Сургалтын түгээмэл чиглэл  
Б- Бакалавр, М- Магистр

### Бакалавр

37473 ам.доллар (кредит)

### Магистр

32263 ам.доллар (8 кредит)

### Англи хэлний институт

26300 ам.доллар

*Зардалд сургалтын төлбөр, хураамж, оюутны хотхоны өрөө, хоол, эрүүл мэндийн даатгал, бусад зардал багтана.*

*АХХ-ийн зардалд кредит оноотой хичээлд хавсран суралцах зардал багтахгүй.*

Харилцаа холбоо, сэтгүүл зүй (Б),  
компьютер, мэдээллийн шинжлэх ухаан (Б),  
Инженер технологи (Б,М),  
Боловсрол (Б)  
Англи хэл, уран зохиол (Б,М),  
Биологийн болон физикийн шинжлэх ухаан (Б,М)  
Сэтгэл судлал (Б,М)  
Нийгмийн шинжлэх ухаан (Б, М)  
Дүрслэх болон театрын урлаг (Б)  
Бизнес, менежмент, маркетинг (Б)  
Төрийн захиргаа, нийгмийн халамж үйлчилгээ (Б)  
Эрүүл мэнд, холбогдох эмнэлзүйн шинжлэх ухаан  
(Б, М)  
Математик, статистик (Б, М)  
Эрүүл мэнд, спортын шинжлэх ухаан (Б, М)

## Англи хэлний институт

Гадаад оюутнуудад англи хэл заах мэргэжлийн багш нар АХХ-д суралцаж буй бүтэн цагийн оюутнуудад долоо хоног 18-22 цаг англи хэлний хичээл заана. Энэ кредит оноогүй хөтөлбөр бакалавр, магистрын сургалтын хичээлд суралцахад тавьдаг элсэлтийн шаардлагыг хангана. Олон улсын оюутнууд нөхцөлтэй журмаар элсэн суралцах боломжтой.

Level One  
22 hrs. ESL

Level Two  
22 hrs. ESL

Level Three  
22 hrs. ESL

Level Four  
18 hrs. ESL  
up to 3 undergraduate  
college credits

Level Five  
18 hrs. ESL  
up to 6 undergraduate  
college credits

Level Six  
18 hrs. ESL  
up to 6 undergraduate  
college credits

# QUALITY EDUCATION CENTRAL LOCATION



## Миллерсвил Их сургуулийн элсэлтийн шаардлага

Миллерсвил Их сургуульд суралцах хүсэлтэй бүх гадаад оюутнууд дараах зүйлийг бүрдүүлэх шаардлагатай.

### Бакалавр

- Өргөдөл, өргөдлийн хураамж
- Албан ёсны сурлагын дэвтрийн хуулбар\*
- Англи хэлний мэдлэгийн тодорхойлолт
- Санхүүгийн дэмжлэгийн тодорхойлолт
- Паспортын хувь хүний мэдээллийн хуудасны хуулбар

### Магистр

- Өргөдөл, өргөдлийн хураамж
- Албан ёсны сурлагын дэвтрийн хуулбар\*
- Сурах зорилгоо илэрхийлсэн тодорхойлолт
- Бакалаврын сургалтын элсэлтийн шалгалт (хөтөлбөрт суурилсан)
- Англи хэлний мэдлэгийн тодорхойлолт
- Гурван тодорхойлолт
- Санхүүгийн дэмжлэгийн тодорхойлолт
- Паспортын хувь хүний мэдээллийн хуудасны хуулбар

### Англи хэлний институт

- Өргөдөл
- Сурлагын дэвтрийн хуулбар
- Англи хэлний мэдлэгийн тодорхойлолт (заавал бус)
- Санхүүгийн дэмжлэгийн тодорхойлолт
- Паспортын хувь хүний мэдээллийн хуудасны хуулбар

## Англи хэлний мэдлэгийн түвшин

Бакалавр (70 iBT, 6.0 IELTS, 54 PTE, 169 Cambridge, 4.0 iTEP, 2A STEP-EIKEN)

Магистр (81 iBT, 6.0 IELTS, 61 PTE, 177 Cambridge, 4.0 iTEP, 2A STEP-EIKEN)

### ДАРААХ ЗҮЙЛИЙГ АНХААРНА УУ.

- Миллерсвил Их сургуулийн байгууллагын код нь 2656
- Бүх баримт бичиг албан ёсны, эх хувь эсвэл нотариатаар баталгаажуулж гэрчилсэн эх хувийн хуулбар байх ёстой. Та өөрт байгаа цорын ганц эх хувиа илгээж болохгүй.
- АНУ-аас өөр улс орны коллеж эсвэл их сургуулийн дипломтой оюутнууд албан ёсны дипломоо боловсролын үнэлгээний магадлан итгэмжлэгдсэн алба руу илгээж, хичээл тус бүрээр үнэлгээ хийлгэх ёстой.

## Өргөдлийн материалыг дараах хаягаар илгээнэ үү.

### Бакалаврын сургалтын элсэлтийн алба

Миллерсвил Их сургуулийн элсэлтийн алба  
Шуудангийн хайрцаг 1002  
Миллерсвил хот, ПА 17551-0302  
Утасны дугаар: 717-871-4625  
Имэйл: [admissions@millersville.edu](mailto:admissions@millersville.edu)

### Магистрын сургалтын элсэлтийн алба

Миллерсвил Их сургуулийн Магистрын сургалт  
Шуудангийн хайрцаг 1002  
Миллерсвил хот, ПА 17551-0302  
Утасны дугаар: 717-871-4723  
Имэйл: [gradadmissions@millersville.edu](mailto:gradadmissions@millersville.edu)

### Англи хэлний институт

Миллерсвил Их сургуулийн глобал боловсрол  
Шуудангийн хайрцаг 1002  
Миллерсвил хот, ПА 17551-0302  
Утасны дугаар: 717-871-7506  
Имэйл: [GlobalEducation@millersville.edu](mailto:GlobalEducation@millersville.edu)



@millersvilleu